

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ						
№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
1	Журам батлах тухай 2013.05.14 А/477	1. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим мэдээллийн сан, мэдээллийн систем, түүнийг дэмжих дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг хавсралтаар баталсугай. 2. Байгууллагын үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад, мэдээлэл, мэдээллийн систем, түүний дэд бүтцийн аюулгүй байдалтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.	Журмыг албан хаагчдад сурталчлан танилцуулах, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах Компьютерийн хортой кодын эсрэг албан ёсны лицензтэй програм хангамжаар хангах ажиллах	Уг журмыг цахим майл хаяг, дотоод сүлжээний програмаар дамжуулан албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа уг журмыг болон “НХХААГ-ын Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг давхар мөрдлөг болгон ажиллаж байна. Өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдлыг хангах зааварчилгааг өгч ажиллаж байна. Албан хаагчдын компьютерын вирусны эсрэг нэг жилийн албан ёсны эрхтэй “bitdefender security” програм суулгаж хэвийн үйл ажиллагааг хангав.	100%	Байгууллагын мэдээллийн технологийн аюулгүй байдал бүрэн хангагдана.
2	Хөтөлбөр журам батлах тухай 2014.05.30 № А/451	1. “Нийслэлийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Энэхүү “Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” журмын хэрэгжилтийг хангаж, нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэж байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад хүргэн сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан тогтмол хяналт тавьж ажиллахыг дүүргийн засаг дарга нар болон нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн /-т үүрэг болгосугай.	Журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 4 зорилтын хүрээнд 34 ажлыг тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Нийслэлийн “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр-ийн хүрээнд “Тэжээл” дэд хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 232 дүгээр тогтоолоор батлуулан ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 2016- 2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн нийгэм эдийн засгийн 2017 оны зорилтод эрчимжсэн мал аж ахуйн талаарх ажлуудын саналыг тусган батлуулан ажиллалаа. Сүүний үхрийн фермийн аж ахуйн үндэсний стандартын төслийг 3 цувралаар боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Нийслэлийн мал аж ахуй эрхлэх мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар 6 дүүргээс санал авч, ажлын танилцуулга, захирамжийн төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч, Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/463 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан ажиллаа.	90%	Хөтөлбөр хэрэгжсэнээр Нийслэлийн мал аж ахуйг цогцолбор байдлаар эрчимжүүлэн хөгжүүлж, хотын хүн амыг эрүүл, аюулгүй, экологийн цэвэр хүнсээр хангах нөхцөл бүрдэж, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэнэ.
3	Журам батлах тухай 2014.12.24 №А/1063	1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4-т заасан “Орон сууцны дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор нийслэлийн өмчлөлд шилжсэн орон сууцыг Төрийн албан хаагчдад худалдах журмыг нэгдүгээр хавсралтаар, орон сууц	Журмыг албан хаагчдад танилцуулж, уг журмын болзлыг хангаж буй албан хаагчдын судалгаа гаргах, хамруулах	Орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах хүсэлтэй албан хаагчдыг бүртгэж, журмын дагуу шаардлагыг хангаж буй албан хаагчдын судалгааг гаргасан. Нийслэлийн Засаг даргын 2014 оны 12 сарын 24-ний өдрийн А/1063 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан орон сууцнаас	100%	Албан хаагчид хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар газрын албан хаагчийн нийгмийн

		худалдах гэрээг хоёрдугаар хавсралтаар, орон сууцныг хуваарилах хуваарийг гуравдугаар хавсралтаар баталсугай.		нийслэлийн төрийн албан хаагчдад худалдах журмыг нийт албан хаагчдад танилцуулсан. НҮХААГ-ын УБ-орон сууц сангаас албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журмыг газрын даргаар батлуулж, Эрчимжсэн мал ах ахуйн хэлтсийн дарга Т.Дэлгэрсайхан, мэргэжилтэн О.Батжаргал, Захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн нар "Орон сууцны дэд хөтөлбөр"-т хамрагдсан /"Цагаан хуарн хотхон"/		баталгаа хангагдаж, ажиллах идэвхи сонирхол нэмэгдэнэ.
4	Ноос боловсруулах үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.03.30 № А/230	1. Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтийн дагуу малын гаралтай анхан шатны боловсруулалт хийгдээгүй ноосон түүхий эдийг Улаанбаатар хотод 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн оруулахгүй байх шаардлагатай арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Улаанбаатар хотын Цагдаагийн газар /Ч.Болдбаатар/, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын Цагдаагийн газар /Ч.Жаргалсайхан/, нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.	Арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд стандартыг мөрдөх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Ноос, ноолуурын холбоо, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо болон үйлдвэрлэл эрхлэгчидтэй 2015 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр тус захирамжийг хэрэгжүүлэн ажиллах, цаашид авах арга хэмжээний талаар уулзалт зохион байгуулсан. Захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөнд холбогдох байгууллагуудаас санал авч, батлуулсан. Төлөвлөгөөнд 2015-2017 онуудад стандартын шаардлага хангаж ажилласан үйлдвэрүүд ноос хүлээн авч, үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркад ноос ноолуурын анхан шатны угаах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх ажилд мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах талаар тусгагдсан. Төлөвлөгөөний дагуу Ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2015 оны 04 дүгээр сарын 8-14 өдрүүдэд хийж гүйцэтгээд байна. Мөн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын удирдамжаар Арьс шир, ноос ноолуур болон цаас боловсруулах үйлдвэрүүдэд 09 дүгээр сарын 09-22-ны өдрүүдэд арьс шир боловсруулах 22, ноос ноолуур боловсруулах 13, ахуйн цаасны 4 нийт 39 аж ахуйн нэгжид шалгалт хийлээ. Шалгалтын Нэгдсэн тайлан дүгнэлтийг Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд танилцуулсан.	100	Боловсруулаагүй түүхий ноосыг Улаанбаатар хот уруу оруулахгүй хориглосноор бохирдлын хэмжээг багасгах, цэвэрлэх байгууламжуудыг ачааллыг бууруулах
		2. Аж үйлдвэрийн яам, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэхийг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т даалгасугай.	Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Засгийн газраас ноос боловсруулах үйлдвэрүүдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Өвөрхангай, Баянхонгор, Төв, Хэнтий зэрэг аймгуудад 12 ноос угаах үйлдвэр үйлдвэрийн барилга байгууламжаа барин, тоног төхөөрөмжөө суурилуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрээ шилжүүлэн Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод байршуулж байгаа Ноос Ирээдүй ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаатай Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын удирдлагууд болон Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн	90	Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,

				<p>холбооны төлөөлөл очиж танилцсан. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркт арьс шир ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг шилжүүлэх ажлын хүрээнд паркийн Техник эдийн засгийн үндэслэл /250 сая төгрөг/, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл /500 сая төгрөг/, Усны эрэл хайгуулын ажил /300 сая төгрөг/, барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн ажил /375 сая төгрөг/, Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл /110/35/10 дэд өртөө 57,7 сая төгрөг/, үерийн усны байгууламжийн зураг төсөл /56,9 сая төгрөг/, ундны усны байгууламжийн зураг төсөл /74,9 сая төгрөг/, технологийн усан хангамжийн зураг төсөл /74,6 сая төгрөг/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол /120 сая төгрөг/, арьс ширний үйлдвэрүүдийн технологийн түвшний үнэлгээг /23,2 сая төгрөг/ тус тус гүйцэтгүүлж хүлээн авсан. Мөн 2017 онд дулааны цахилгаан станц, ундны усан хангамжийн байгууламж, үйлдвэрийн технологийн усан хангамжийг концессын гэрээгээр гүйцэтгүүлэхээр концессын зүйл жагсаалтад саналаа хүргүүлсэн.</p>	ноос угаах үйлдвэрүүдийг нүүлгэх ажлыг эрчимжүүлэх
5	<p>Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай</p> <p>2015.07.24 № А/625</p>	<p>1. Монгол Улсын санхүү, эдийн засгийн хүндрэлтэй байдал, нийслэлийн төсвийн орлогын төлөвлөгөөний тасалдалтай уялдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Дүүргийн Засаг дарга, бүх шатны орон нутгийн төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.Үүнд:</p> <p>а. Төсвийн урсгал зардлыг хэмнэх, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр бүх талын арга хэмжээг хэрэгжүүлж, өр, авлага үүсгэхгүй ажиллах;</p> <p>б. Төсөвт байгууллагын “хангамж бараа материалын зардал”-ын бүлгийн (бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авах) нийт төсвийн хэмжээг 40 хувиар бууруулж зарцуулах;</p> <p>в. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагаас бусад төсөвт байгууллагын “нормативт зардал” бүлгийн (эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, нормын хувцас) нийт төсвийн хэмжээг 50 хувиар бууруулж зарцуулах;</p> <p>г. Төсөвт орлого төвлөрүүлэх онцлогтойгоос бусад төрлийн улсын мэдээллийн маягт бэлтгэх зардлын хэмжээг 50 хувиар зарцуулах;</p> <p>д. Орон нутгийн төсвөөс олон улсын байгууллага болон нийслэл, дүүргийн өмчит аж ахуйн нэгжийн дүрмийн санг нэмэгдүүлэх, эх үүсвэр нэмэгдүүлэх, гишүүнчлэлийн төлбөрийн зардлыг нийслэл, дүүргийн төсвийн тодотгол хийж дуусах</p>	Урсгал төсвийн зардлыг хувиар бууруулж ажиллах 20	<p>1. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласантай холбогдуулан төсвийн хэмнэсэн орлогыг төвлөрүүлэх шилжүүлгээр төсөвт буцаан төвлөрүүлсэн.</p> <p>2. 2016 оны хувьд төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж тэвчиж болох зардал буюу ном хэвлэл, хичээл үйлдвэрлэлийн дадлага явуулах зардал болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100%

		хүртэл хойшлуулах; е. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт болон төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэлийг харгалзан төсвийн зардлыг үе шаттай санхүүжүүлэх.				
6	Улаанбаатар хотын багц дүрмийг боловсруулах төслийг зохион байгуулах тухай 2016.03.01 №А/164	1.“Улаанбаатар хотын багц дүрэм”-ийг боловсруулах төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдийг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гэрээ байгуулан ажиллаж буй “Ач холдинг” ХХК-д зорилтод тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтарч ажиллахыг харьяа агентлаг, газрын дарга, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Ирүүлсэн дүрмийн төсөлтэй танилцаж, санал хүргүүлнэ.	Манай байгууллагагаас санал авахаар “Угаалга, хуурай хими цэвэрлэгээ”, “Ус”, “Дуу чимээ”, Хотын ногоон байгууламж”, “Мал, тэжээвэр амьтан” гэсэн 5 дүрмийн төсөл ирүүлсэний дагуу холбогдох саналыг хүргүүлсэн болно.	100%	Салбарын онцлог дүрэмд тусгагдана
7	Нийслэлийн их ба нээлттэй өгөгдлийг зохицуулах журам батлах тухай 2016.03.03 А/170	1.Нийслэлийн бүх шатны байгууллагуудын өгөгдөл, өгөгдлийн сан, сервер системийг нийслэлийн дата төвд байршуулж, их өгөгдөл үүсгэх, нийслэлийн дата төвтэй шууд холболт үүсгэх, зарим өгөгдлийг иргэдэд нээлттэйгээр нийтлэх, түүнийг дэмжих, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор “Нийслэлийн их ба нээлттэй өгөгдөл зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай. 2.Байгууллагын үйл ажиллагаандаа батлагдсан журмыг мөрдлөг болгон ажиллахыг нийслэлийн бүх шатны байгууллагуудын удирдлагуудад, өгөгдөл, өгөгдлийн сан, түүний аюулгүй байдлыг хангаж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.	Байгууллагын хэмжээнд байгаа нээлттэй өгөгдлүүдийг http://data.ulaanbaatar.mn/ дээр бүртгэх	Байгууллагын хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар их ба нээлттэй өгөгдлүүд одоогоор байхгүй байна.	100%	Байгууллагын өгөгдөл иргэдэд нээлттэй хүртээмжтэй болно.
8	Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай 2016.03.21 А/222	2. Батлагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т, гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Л.Нарантуяа/-т, техник тоног төхөөрөмж худалдан авах ажилд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагаа зохион байгуулах - 90 үнээний зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах - Дэд бүтцийн ажлуудыг хийх - Хадлан, тэжээл техник тоног төхөөрөмж - Бага оврын газар тариалангийн техник, тоног төхөөрөмж	-Газрын даргын 2015.09.10-ны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй НҮХААГ-16/001 тоот тендерийн урилгыг 2016.01.29-ний өдрийн Өдрийн сонин, Өглөөний сонин болон e-procurement.mn сайтанд тавьж нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тендерт 8 компани оролцсоноос “Сайн констракшн” ХХК шалгарч, А/631 дугаар захирамжийн дагуу НХӨГ-т зөвлөмжийг хүргүүлсэн. -Тог цахилгааны ажлын тендерт “Эрчим Өгий” ХХК, Усан хангамжийн ажлыг гүйцэтгэх тендерт “Эрдэнэдриллинг” ХХК, Фермийн хашаа, хайс барих ажлын тендерт “Хан жаргалант стоунс” ХХК-ууд тус тус шалгарч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. “ХАА-н дунд оврын трактор болон хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах” тендерт “Энсада трактрон” ХХК шалгарч, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ний А/18 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа. -“Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног,	100%	Малын бэлчээрийг хүн малын талхагдал, цөлжилтөөс хамгаална. Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэт технологи нэвтрүүлэн малын ашиг шимийг сайжирна.

				төхөөрөмж” худалдан авах тендерт 4 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Мула” ХХК, “Зүлгэнтээг агрокорпораци” ХХК-нуудын түншлэл шалгарч гэрээ байгуулсан боловч хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ нийлүүлээгүйгээс гэрээг цуцлаж, тендерийг дахин зарласан. Тус тендерт 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Хаш техник” ХХК шалгарсан. Гэвч Монгол улсын засгийн газрын 2016 оны 8 дугаар сар 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сар 17-ноос хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй, гэрээ байгуулахгүй байхаар холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасны дагуу тендерийг цуцалсан.		
9	Бүгд Найрамдах Солонгос Улсын Пусан хотод томилолтоор ажиллуулах тухай 2016.08.19 А/611	2. Албан томилолтын тайланг ирснээс хойш 7 долоо хоногийн дотор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэнд үүрэг болгосугай.	БНСУ-ын Пусан хотын Гадаад харилцааны хэлтэс болон Пусан Олон улсын хамтын ажиллагааны сангийн урилгаар Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах уулзалт, сургалтад хамрагдах.	Тус сургалтад БНСУ-ын Пусан хоттой ах дүүгийн хамтын ажиллагааны харилцаатай Зүүн өмнөд Азийн 5 орны төрийн байгууллагын 16 төлөөлөгч хамрагдаж өөрийн өөрийн орон болон хотуудынхаа газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар илтгэл тавилаа. Сургалтын хугацаанд БНСУ-ын төрөөс газар тариалан эрхлэгчдээ дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд, Пусан хотын хөдөө аж ахуйн салбарын эрчимтэй хөгжилтэй танилцаж, туршлага судаллаа. Сургалтаар үзэж танилцсан үйл ажиллагаануудаас Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгох, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгддөг GAP, ORGANIC, NONPESTICIDE, зэрэг стандартын шаардлага нийцэхүйц бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгож, хүн амын хүнсний аюулгүй байдлыг дээд зэрэгт үзэж байгаа нь нэн чухал байлаа. Мөн хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд нэгдэн хоршоо, бүлэг байгуулан газар тариалан эрхлэгчдээс бүтээгдэхүүнийг худалдан авч савлан, худалдааны сүлжээгээр дамжуулан хямд үнээр иргэдийн хүнсэнд нийлүүлж байгаа нь хүнсний нийлүүлэлтэд оруулж нэвтрүүлэхүйц санаа байлаа. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн ажлыг хөнгөвчлөх, зардлыг хэмнэх, бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор төрөөс орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулан хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаа нь хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, ажиллах хүч багатай манай улсын хувьд нэвтрүүлүүштэй санаа байлаа. 2016 оны 08 дугаар сарын 03-ний өдөр Улаанбаатар хот Пусан хотын хооронд хамтарч ажиллах санамж бичиг байгуулагдсан ба энэ ажлын хүрээнд нийслэлийн хөдөө аж ахуйн	100%	Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэн, туршлага солилцож, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах.

				<p>салбарт доорх чиглэлээр хамтарч ажиллах саналыг Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн тавилаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд байрлах “Нийслэлийн төв” агропарк байгуулах зориулалтаар олгосон төрийн эзэмшлийн 8 га талбайд “Сургалт үйлдвэрлэлийн төв” байгуулах, үүгээр дамжуулан иргэдэд тоног төхөөрөмжийн түрээсийн болон засварын үйлчилгээ үзүүлэх, шинэ төрлийн таримлуудыг турших, нутагшуулах, тариалах, сайн соортын үр үйлдвэрлэлийн ажил эхлүүлэх - Хотуудын хооронд хөдөө аж ахуйн чиглэлээр оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, хөнгөлөлттэй сургах - Төрийн байгууллагын ажилчид болон фермерүүдийг урт болон богино хугацааны сургалтуудад хамруулах, туршлага судлуулах - Пусан хотоос газар тариалангийн мэргэжилтэн урьж газар тариалан эрхлэгчдэд сургалтууд явуулах, зөвлөгөө авах - Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг сайжруулах, бий болгоход тусламж дэмжлэг авах, хамтран ажиллах - ХАА-н чанарын баталгаажилтын лаборатори байгуулахад дэмжлэг авах, хамтран ажиллах зэрэг саналыг тавилаа. <p>Тус уулзалт, сургалтын хаалтын ажиллагаанд БНСУ-ын орон нутгийн хөгжлийн байгууллага, Пусаны Хөдөө аж ахуйн их сургууль, Пусан хотын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг иргэдэд нэвтрүүлэх төвийн дарга, удирдах ажилтнууд болон Пусаны олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Зүүн өмнөд ази хариуцсан 2 дугаар дарга оролцож Улаанбаатар хотын зүгээс тавьсан хүсэлтийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн ба Нийслэлийн засаг даргын тамгын газрын Гадаад харилцааны хэлтсээр дамжуулан албан ёсоор санал хүргүүлэхээр боллоо.</p>		
10	Төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай 2016.08.30 А/630	1. Улаанбаатар хотын иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний ногоо, жимс, жимсгэний аж ахуй эрхлэгчдийг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгоор жил бүрийн 8 дугаар сарын 25-аас 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд “Алтан намар үзэсгэлэн худалдаа”-г зохион байгуулсугай.	“Алтан намар үзэсгэлэн худалдааг” дүүрэг тус бүрт 2-оос доошгүй байршилд зохион байгуулах	Нийслэлийн 6 дүүргийн 49 байршил 500 гаруй цэгт орон нутгийн болон дүүргүүдийн ногоочид 421 тонн төмс, 265 тонн хүнсний ногоо, 14051 шил даршилж нөөшилсөн өргөст хэмх, улаан лооль, 3045 кг зөгийн бал, 5-6 нэр төрлийн эмийн болон гоёл чимэглэлийн 2500 гаруй мод бутыг худалдаж 555,1 сая төгрөгний борлуулалт хийсэн байна.	100%	- Иргэд тодорхой байрлалаас өдөр тутам шинэ ногоогоо худалдан авч байна. - Ажлын байрны тоо нэмэгдэж ногоочдын эдийн засгийн чадамж нь дээшилж байна. -Хүнсний

					ногооны нэр төрөл нэмэгдэж, борлуулалт сайжирсан.	
11	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай 2016.08.31 А/635	1. Монгол Улсын Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралт ёсоор баталсугай. 2. Байгууллагын дүрмийн төслийг боловсруулж, 2016 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, батлах арга хэмжээ авахыг энэ захирамжийн хавсралтад заасан Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарт даалгасугай.	Байгууддагын дүрмийн төсөл, ажлын байрны тодорхойлолт боловсруулах.	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрэм 2016 оны 10 дугаар сарын 27 –ны Нийслэлийн Засаг даргын А/758 захирамжаар батлагдсан. Байгууллагын дүрэм батлагдсантай уялдуулан 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/19 тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам батлан ажлын байрны тодорхойлолт боловсруулан байгууллагын даргаар батлуулав.	100%	Байгууллагын дүрэм, ажлын байрны тодорхойлолт батлагдсан байна.
12	“Улаанбаатар түншлэл-2016” олон улсын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах тухай 2016.09.06 А/641	3. “Улаанбаатар түншлэл-2016” олон улсын үзэсгэлэн, яармагийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, гадаад, дотоодын үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулан, дүнг Нийслэлийн болон Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын удирдлагуудад танилцуулахыг Зохион байгуулах хороо /Ж.Батбаясгалан/-нд үүрэг болгосугай.	Гадаад, дотоодын үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулах.	Монгол Улсад худалдааны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойд зориулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран “Улаанбаатар түншлэл – 2016” намрын үзэсгэлэн, яармагийг 2016 оны 9 дүгээр сарын 08-аас 11-ний өдрүүдэд “Мишээл Экспо” төвд 4 хоног зохион байгуулагдсан бөгөөд дотоодын 110 аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчид оролцсоноос Хүнсний салбарын 39 аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 9 аж ахуйн нэгж, хөнгөн үйлдвэрийн салбарын 30, ном, бичгийн хэрэгслийн 3, үнэт эдлэлийн 3, барилгын салбарын 3, бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, импортын бүтээгдэхүүн үйлчилгээний 21 аж ахуйн нэгж, байгууллагууд тус тус оролцож үзэсгэлэнгийн Зохион байгуулах хорооноос шилдгийн шилдэг байгууллагуудаа шалгаруулж нийт 157,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Тус үзэсгэлэнгийн Алтан түншээр “Жүр үр” ХХК, “Глобал Трейдинг Девелопмент” ХХК, Ерөнхий ивээн тэтгэгчээр “Батбайгаль” ХХК, ивээн тэтгэгчээр “Алтан тос” ХХК-иуд тус тус хамтран ажиллалаа.	100%	Гадаад, дотоодын үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулан Бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулан таниулах
13	Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2016.09.13 А/644	1. Монгол Улсын Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн баталсны дагуу Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /хуучин нэрээр/-ын хэрэгжүүлж байсан үйлдвэрлэлийн харилцаатай холбогдсон чиг үүргийг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Үйлдвэрлэл, инновацийн газарт шилжүүлсүгэй. 2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад даалгасугай.	Захирамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу нэр бүхий албан хаагчдыг мэргэжил, мэргэшлийн дагуу шилжүүлж, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу нэг удаагийн тэтгэлэг олгож, нийгмийн даатгалын болон татварын байгууллагуудтай	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/644 дүгээр захирамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу мэргэжилтэн Б.Ганцэцэг, Ж.Содцэцэг, Ч.Чулуунцэцэг, Ц.Төмөрбаатар, Ц.Буянжаргал, Д.Энхцэцэг нарыг Газрын даргын 2016 оны Б/23 тушаалаар Үйлдвэрлэл, инновацийн газарт шилжүүлж, хувийн хэрэг, нийгмийн даатгалын дэвтрийг хүлээлгэж өгсөн. Тус захирамжийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасны дагуу манай байгууллага нь өөрчлөлт хийж, бусад албан хаагчдаа чөлөөлж, шинэ бүтцээр томилж зохион	100%	Захирамжийн хэрэгжилт хангагдаж байгууллагын үйл ажиллагаа жигдэрнэ

			тооцоо хийж дуусгах.	байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу нэг удаагийн тэтгэлэг олгож, нийгмийн даатгалын болон татварын байгууллагуудтай тооцоо хийж дуусгав.		
14	Дүрэм батлах тухай 2016.10.27 А/758	1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрмийг албан хаагчдад танилцуулах.	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрмийг албан хаагчдад танилцуулан дүрэм батлагдсантай уялдуулан 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/19 тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам батлав.	100%	Байгууллага үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлнэ.
15	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2016.11.18 А/811	1.Согтууруулах ундааны болон тамхины үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, тэдгээрийн үйлдвэрлэл болон тамхины импортын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2.Үйл ажиллагаандаа “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”, “Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ыг тус тус мөрдөж ажиллахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т үүрэг болгосугай.	-тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн үйлдвэрт Ажлын хэсэг очиж ажиллах -Ажлын хэсгийн дүгнэлтийг ХХААХҮЯ-д хүргүүлэх	Согтууруулах ундааны болон тамхины үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих, тамхины импортын үйл ажиллагаанд хяналт тавих Ажлын хэсэг тамхины импортын үйл ажиллагаа эрхэлдэг “Волтам” ХХК, “Алтангадас” ХХК, “Сютл бимекс” ХХК-дын үйл ажиллагаатай танилцаж, Ажлын хэсгээс гарсан дүгнэлтийг үндэслэн саналыг ХХААХҮЯ-д хүргүүлсэн.	100%	Төрөөс баримтлах бодлого хэрэгжиж, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал сайжирна.
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					98,7	

Биелсэн:13
Хэрэгжих шатанд:2
Хугацаа болоогүй:
Тасарсан:0
Үнэлгээгүй ажил:0